

БАТЛАВ "ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ "ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН
Б.АЛТАНЦЭЦЭГ



"Дарханы Дулааны Сүлжээ" ТӨХК-ийн 2016 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө

2016 оны 01 дүгээр сарын 05

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хариуцах этгээд
1	Авлигын эсрэг авч авах арга хэмжээг боловсруулах	1.1.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулан, АТГ-т хүргүүлэх	1 дүгээр улирал	Гүйцэтгэх захирал
2	Эрх бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ийг тогтоосон хугацаанд АТГ /ТӨХ/-д биечлэн хүргэх	2.1.ХАСХОМ мэдүүлэх этгээдүүдийн жагсаалтыг гаргах, хүргүүлэх 2.2.Хуулийн хугацаанд ХАСХОМ-г нэгтгэн авч, цахимаар бүртгэн, баталгаажуулж, цаасаар хэвлэн хүргэх		Хуулийн зөвлөх
3	Авлигын эсрэг хууль тогтоомжийг ажилтнуудад сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд чөлөөтэй авах нөхцлийг хангах	3.1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал 3.2.Авлигатай Тэмцэх Газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг албан хаагчдад түгээх	Тухай бүр	ЗУХ-ийн дарга Хуулийн зөвлөх Мэдээлэл сурталчилгааны мэргэжилтэн ИА-ны дарга
4	Техникийн нөхцөл, түүний талаархи мэдээллийг хэрэглэгчдэд нээлттэй болгох	4.1.Техникийн нөхцөл авахад бүрдүүлэх материал 4.2. Техникийн нөхцөл олгох журам 4.3.Тухайн техникийн нөхцөл авсан хэрэглэгчдийн товч мэдээ	1 дүгээр улирал Тухай бүр	Мэдээлэл сурталчилгааны мэргэжилтэн

5	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	5.1.Сул орон тооны ажлын байрны зарыг цахим хуудсанд байршуулах	Тухай бүр	ЗУХ-ийн дарга Мэдээлэл сурталчилгааны мэргэжилтэн
		5.2.Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх	2 дугаар улирал	
		Хүний нөөцийн сонгон шалгаруулалтын журам цахим хуудсанд тавих		
6	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	6.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах	1 дүгээр улирал	Хангамжийн хэлтсийн дарга Мэдээлэл сурталчилгааны мэргэжилтэн
		6.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх		
		6.3.Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байх	Тухай бүр	
		6.4.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/-ийг цахим хуудсанд байршуулах		
		6.5. 5 сая, 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй болон тендерийн журмаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсанд байршуулсан байх		
		6.6.Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх		
		6.7.Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулах		
7	Ажилтан нэг бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	7.1. Ажилтан нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх	2 дугаар улирал	ЗУХ-ийн дарга Хуулийн зөвлөх
		7.2.Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах	Тухай бүр	
8	Авлигатай тэмцэх зорилго бүхий ТББ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах	8.1.Авлигын эсрэг тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх	3 дугаар улирал	Гүйцэтгэх захирал Хуулийн зөвлөх
		8.2.Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг тайландаа тусгасан байх		
		8.3.Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа мэдээлсэн байх	Тухай бүр	

9	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	9.1. Ёс зүйн дүрмийг боловсруулах, баталж мөрдүүлэн хэвшүүлэх	2 дугаар улирал	Гүйцэтгэх захирал Хуулийн зөвлөх
10	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	10.1. Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлж цахим хуудсандаа байршуулах 10.2. Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах 10.3. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/ дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах	Тухай бүр	ЗУХ-ийн дарга Мэдээлэл сурталчилгааны мэргэжилтэн
11	Авлигын эрсдэл ба авлига гарах боломж, зөрчил байгууллагынхаа хэмжээнд гаргуулахгүй байх	11.1. Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байх 11.2. Авлигын эрсдэл ба авлига гарах боломж, зөрчил гаргуулахгүй байх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, ажилтнуудын ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан	3 дугаар улирал	Хуулийн зөвлөх ЗУХ-ийн дарга
12	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	12.1. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг биелүүлэх, тайлагнах	Тухай бүр	Хуулийн зөвлөх ЗУХ-ийн дарга
13	Авлигын эсрэг зохион байгуулагдах сургалтад хамрагдах	13.1. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулагдах авлигын эсрэг сургалт, зөвлөгөөнд хамрагдаж энэ талаархи мэдээ мэдээллийг өөрийн байгууллагын удирдах ба бусад ажилтнуудад сурталчлан таниулах	Тухай бүр	Хуулийн зөвлөх
14	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж хуульд заасны дагуу холбогдох	13.1. Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн	Тогтоосон хугацаанд	Ерөнхий ня-бо

	мэдээллийг цахим хуудсанд байршуулах	жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор 13.2.Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байршуулах	Тухай бүр	Мэдээлэл сурталчилгааны мэргэжилтэн
15	Иргэдийн өргөдөл, санал, гомдол, хүсэлтийг хүлээн авч түүнийг шийдвэрлэх шат дамжлагыг боловсронгуй болгох	14.1. Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан ажилтны нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулах	3 дугаар улирал	Гүйцэтгэх захирал Хуулийн зөвлөх
16	Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөх журам, дүрмийг цахим хуудсанд байршуулах	Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Төрийн өмчийн хорооноос дагаж мөрдөх хуульчилсан акт /тушаал, журам, дүрэм, заавар, аргачлал/-ыг хэрэгжүүлэн ажиллах	3 дугаар улирал	Мэдээлэл сурталчилгааны мэргэжилтэн
17	Компанийн эрх бүхий албан тушаалтнууд, ТУЗ-ийн гишүүдийн талаархи мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох	ТУЗ-ийн дарга, гишүүд, компанийн эрх бүхий албан тушаалтнуудын танилцуулгыг цахим хуудсанд байршуулах	4 дүгээр улирал	ТУЗ-ийн нбд Мэдээлэл сурталчилгааны мэргэжилтэн
18	Компанийн үүсгэн байгуулах бичиг баримт болох дүрмийг олон нийтэд нээлттэй болгох	Компанийн дүрмийг цахим хуудсанд байршуулах	3 дугаар улирал	Мэдээлэл сурталчилгааны мэргэжилтэн
19	2015 оны ажлын тайлан гаргаж АТГ-т хүргүүлэх	2015 онд төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлын тайлан тухай бүрээр гаргах	4 дүгээр улирал	Хуулийн зөвлөх
20	Компанийн эрх бүхий албан тушаалтнууд, ТУЗ-ийн гишүүдийн ХАСХОМ, урьдчилсан мэдүүлгийг гарган авах	Ажлын тайланг цаасан хэлбэрээр АТГ-т хүргэж өгөх Компанийн эрх бүхий албан тушаалтан, ТУЗ-ийн гишүүн ажлаас чөлөөлөгдсөн, өөрчлөгдсөн тохиолдолд шинээр орсон этгээдийн урьдчилсан мэдүүлэг, ХАСХОМ-ийг цаасаар гаргуулан авах, түүнийг бүртгэх, хянах, хадгалах, тайлагнах	Тухай бүр	Хуулийн зөвлөх

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:



ХУУЛИЙН ЗӨВЛӨХ Р БАТЖАРГАЛ